БАТЛАВ:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Ч. ХАНДСҮРЭН

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ" ЗАХИРАЛ — Ц.БОЛОР-ЭРДЭНЭ

"ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ" НИЙ ХӨВСГӨЛ АЙМАГ, АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ."ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ" ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6490417

ХЯНАСАН:
ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН — П. НЯМСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
"ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ" БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — Б.НЯМДАВАА

2024 ОН

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд “ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа, Жуулчны мэдээллийн төв” байгуулах ажлын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Нэг. Төслийн товч танилцуулга

Төслийн хүрээнд Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газар (ХУТХГ)-ын хамгаалалтын захиргааны оффис /Жуулчны мэдээллийн төв бүхий 1 давхар байгууламж, авто зогсоол, ногоон байгууламж, явган хүний зам, тохижилтын лед гэрэлтүүлэг, жуулчдад зориулсан мэдээллийн самбар, задгай кафе, модон сандал зэргийг барихаар төлөвлөөд байна. үйл ажиллагааны хүрээнд нэг дор 50, өдөрт 1400 аялагч хүлээн авахаар төлөвлөөд байна.

“ХУТХГ-ын хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын аялал жуулчлал, үйлчилгээний төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулгыг баримтлан боловсруулаа.

“ХУТХГ-ын хамгаалалтын захиргаа, жуулчны мэдээллийн төв” төслийн 2024 оны хийгдсэн ажлыг хувиар тооцон үзүүлэв.

Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл/Ажил тус бүрээр хувиар/

Д/д	Ажил	2024 оны төлөвлөгөөт ажил /үе шатны ажлаар/	Ажил хэрэгжилтийн түвшин	Тайлбар
	Бэлтгэл ажил	Төслийн талбайн тохижилт	100.00%	
		Ажилчдын амрах байр тохижилт	100.00%	
1	Мэдээллийн төвийн барилга	Бэлтгэл ажил	100.00%	
		Газар шорооны ажил	100.00%	
		Суурийн ажил	100.00%	
		Шалны ажил	0.00%	
		Гадна бохирын байгууламж хийх ажил	0.00%	
		Гадна бохирын шугам сүлжээний ажил	0.00%	
		Гадна цахилгааны ажил	100.00%	
		Хүрээ газардуулгын ажил	100.00%	
Ажил гүйцэтгэлийн хувь			70.00%	
2	Жанхай АЦБ	Бэлтгэл ажил	100.00%	
		Газар шорооны ажил	100.00%	
		Суурийн ажил	50.00%	
		Гадна бохирын байгууламжны ажил	60.00%	
		Гадна бохирын шугам сүлжээний ажил	100.00%	
		Гадна Цахилгааны ажил	0.00%	
Ажил гүйцэтгэлийн хувь			68.00%	

3	Мөрөн дахь АЦБ	Бэлтгэл ажил	100.00%	
		Газар шорооны ажил	100.00%	
		Суурийн ажил	100.00%	
		Дотор бохирын хоолой холболтын ажил	0.00%	
		Хүрээ газардуулгын ажил	0.00%	
Ажил гүйцэтгэлийн хувь			60.00%	
4	Худгын ажил	Бэлтгэл ажил	100.00%	
		Худаг гаргах ажил	100.00%	
		Газар шорооны ажил	100.00%	
		Суурийн ажил	100.00%	
		Өрлөгийн ажил	100.00%	
		Дээврийн ажил	100.00%	
		Хаалга цонх суулгах ажил	100.00%	
5	Гадна мэдээллийн сүлжээ	Кабель утас татах	0.00%	
Ажил гүйцэтгэлийн хувь			100.00%	

Хоёр. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбайд ажил гүйцэтгэж байх үед тоосжилт үүсэхээс сэргийлж хурдны хязгаарыг оператор бүрт сануулж анхааруулж ажилсан ба авто зогсоолыг хайрган хучилттайгаар шийдэж өгсөн.

Зураг 1: Төслийн талбайн авто зогсоол

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд “ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа, Жуулчны мэдээллийн төв” байгуулах ажлын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Жуулчны мэдээллийн төвийн барилгын талбайд хог хаягдлыг ангилан ялгах сав байршуулж, гарсан хог хаягдлыг Бор Согоот ХХК-ын ангилан ялгах цэгт хүлээлгэн өгч ажиллав.

Зураг 2. Хог ангилан ялгах сав



ЦХ Маягт Т-1

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр:
Регистрийн №
Хаяг:
Утас, факс
Э-Шуудан:
Банкны нэр
Банкны дансны дугаар

Хариуцагч:
Байгууллагын нэр:
Регистрийн №
Хаяг:
Гэрээний №
Нэхэмжилсэн огноо:
Төлбөр хийх хугацаа:

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1		2 бх	60000	100000
			Дүн	
			НӨАТ	
			Нийт дүн	100000

Монгөний дүн

болно.

(Тамга)

Захирал: (Үсгээр)

Нягтлан бодогч:

Мөн мэдээллийн төвийн барилгын талбайд эрэгтэй, эмэгтэй Био 00-г суурилуулсан.

Зураг 3. Био 00 байршуулсан нь:

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд “ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа, Жуулчны мэдээллийн төв” байгуулах ажлын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Төслийн талбайд Жуулчны мэдээллийн төвийн ундны эх үүсвэрийг “Хөвсгөл Цэнгэг Ус” ХХК мэргэжлийн байгууллагаар гаргуулж холбогдох зөвшөөрөл болон паспортжуулсан.

Гүний худаг								
№			Хэмжих нэгж	Нэгж зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Худаг гаргах зөвшөөрөл	Төсөл хэрэгжүүлэгч	Төг	480000₮	1	480000₮	2024	Усны тухай хууль /2012 он
2	Мэргэжлийн байгууллагаар худаг гаргуулах		Төг	34 000 000₮			2024	
3	Худгыг паспортжуулах		Ширхэг	150000₮	1	150000₮	2024	
Нийт зардал					34 630 000₮			

Зураг 4: Худаг гаргах зөвшөөрөл



ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
7 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.
Утас: 70384909
Цахим шуудан: bogazar@khs.gov.mn
Цахим хуудас: Khuvsgul.baigalorchin.gov.mn

2024.09.19 № 465
танай -ны № -т

ХӨВСГӨЛИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНД

Цооног өрөмдөх зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.26 дахь заалт, Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг тус тус үндэслэн Алаг-Эрдэнэ сум Хаттал тосгон Эргийн хошуу нэртэй газарт байрлах тусгай хамгаалалтай газрын байр, мэдээллийн төвийн ус хангамжийн зориулалтаар 50⁰ 24ᴵ 49ᴵᴵ 100⁰ 08ᴵ 30ᴵᴵ цэгийн орчим нэг ширхэг цооног өрөмдөж худаг гаргахыг дараах нөхцөлтэйгээр зөвшөөрөв. Үүнд:

1.Ус хангамжийн зориулалтаар гүний худаг гаргахад зураг төсөлд ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын бүс /200м/-д цэвэрлэх байгууламж төлөвлөсөн байгаа нь боломжгүй байгаа тул Усны тухай хуулийн 22.4, 22.10.2, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230/127 дугаар тушаалаар батлагдсан Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын 3.9.3 цэвэрлэгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулахыг хориглоно гэсэн заалтыг мөрдөх;

2.Усны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу усны мэргэжлийн байгууллагаар цооногийг өрөмдүүлэх, худгийн паспорт бичүүлэн авч, манай байгууллагаар баталгаажуулан, улсын усны мэдээллийн санд бүртгүүлэх;

3.Цооногийг барилгажуулж, усны тоолуур суурилуулах, усны дээжээ лабораторид шинжлүүлэх;

4.Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байх;

Дээрх шаардлагуудыг бүрэн биелүүлээгүй тохиолдолд уг зөвшөөрөл хүчингүйд тооцогдох бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхийг анхааруулъя.

Хувийг: Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн нэгжид

ДАРГА П.МӨНХЖАРГАЛ

Зураг 5: Худаг гаргаж байгаа үе болон барилга баригдаж буй үе

<u>Гурав . Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт</u>

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

<u>Дөрөв . Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт</u>

Хог хаядлын менежментийн төвөллөгөөнд тусгаснаар төслийн талбайд хог ангилан ялгах хогын савыг байрлуулж цугларсан хог хаягдлыг Хатгал тосгоноос 5.5 км, жуулчны мэдээллийн төвөөс 3.0 км зайтай Алаг-Эрдэнэ сумын нутаг, Цагаан бэлчир (2-р баг) баг, Зүүн харганы ам нэртэй газар шинээр баригдсан “Хатуу хог хаягдлын байгууламж, цэвэрлэх байгууламж”-д нийлүүлсэн.

1	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Ахуйн	Үүссэн хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байрлуулах	Төслийн талбай	ширхэг	200000 ₮	9	1 800 000₮	2024 онд	Хог хаягдлын тухай хууль /2017 он
Нийт зардал					**1 800 000₮**				

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд “ХУТХГ-ын Хамгаалалтын захиргаа, Жуулчны мэдээллийн төв” байгуулах ажлын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

<u>Тав . Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт</u>

2024 оны Тухайн жилийн орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөнд төлөвлөсөнөөр шинээр гаргасан гүний худгын уснаас дээж авч Хөвсгөл аймгийн Стандар хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лаборторт шинжилгээнд өгч ажиллав.

Мөн төслийн талбайн хөрсний агрохими, хөрсний эмгэг төрүүлэгч бактерын тоо, хүнд металын шинжилгээг итгэмжлэгдсэн “Нарт Шуүн Консалтинг” ХХК” лаборатортоор хийлгэв.

Зураг 6. Хөрсний дээж цуглуулж буй

Зураг 7: Ундны ус болон орчны хөрсний шинжилгээний үр дүн



Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Лавлагаа Лабораторийн ерөнхий захирлын 2023 оны 01 сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалын 1 дугаар хавсралт Мавт: 00-59

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ

Хөвсгөл аймаг, Мөрөн хот, 8-р баг

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/ : 24-449
Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : Хөвсгөл цэнгэг ус ХХК
/The name of customer's request for analysis/
Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/ : Эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лаборатори

Дээжийн тодорхойлолт /Sample description/					
Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цуврэлын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс Time number of sample-1 manufacturer	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
961	Ундны ус		Монгол Улс	Тодорхойгүй	1.0 л

Хүлээн авсан огноо Date of receipt	Шинжилгээ дууссан огноо Date of test completion	Хэвлэсэн огноо Date of issue of the report
2024 он 09 сар 27 өдөр	2024 он 09 сар 30 өдөр	2024 он 09 сар 30 өдөр

Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилгээн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit	Шаардлага Test specification unit	Шинжилгээний дүн Test results
961	MNS ISO 7150:2006	Аммони	1,5мг/л-с ихгүй	0,03мг/л
	MNS ISO 2572:2011	Кальци	100,0мг/л-с ихгүй	38,1мг/л
	MNS ISO 6059:2005	Магни	30,0мг/л-с ихгүй	12,2мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0,3мг/л-с ихгүй	0,02мг/л
	MNS 6834:2020	Нитрат	50,0мг/л-с ихгүй	0,2мг/л
	MNS 6779:2019	Нитрит	1,0мг/л-с ихгүй	0,0мг/л
	MNS ISO 10523:2001	pH	6,5 - 8,5	7,96
	MNS 6271:2011	Сульфат	500,0мг/л-с ихгүй	5,1мг/л
	MNS 6778:2019	Хатуулаг	7,0мг-экв/л-с ихгүй	2,9мг-экв/л
	MNS 4424:2005	Хлорид	350,0мг/л-с ихгүй	10,6мг/л
	MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1,0 мСм/см-с ихгүй	0,24мСм/см

Санал тайлбар:
Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН
Approved by ЭРХЛЭГЧ: /Г .ЗОЛЗАЯА/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.



“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 24/10-29/1

Захиалагч: **“НБИК” ХХК**
Дээж авсан цэг: **Ирэн Нямдаваа, Хөвсгөл аймаг, Хатгал сум**
Сорьц авсан огноо: **2024 оны 10 сар 24 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **10 сарын 29**

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	$CaCO_3$, %	NO_3, мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca^{+2}	Mg^{+2}	P_2O_5	K_2O
Дээж 1											
1	0-20	8.60	0.045	0.110	6.58	0.48	0.43	42	4	2.9	24

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1								
1	0-20	5.6	61.6	14.3	9.4	2.3	6.8	18.5

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. ПҮР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Пянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (*E.coli*) MNS 3297:2019		*Анаэробын (Cl.perfringens* MNS 3297:2019	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Дээж 1	$6.9*10^5$	≥0.1	1	≥0.1	1

1. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1	0-20	38.5	16.1	0.0	59.3	21.7	16.2
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ,MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

**Харгалзах түвшин* ** Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарн*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, *хөрсний механик бүрэлдэхүүн* MNS6824:2020, *Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт* MNS 5367:2004, MNS6341:2012,*Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр* MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ : Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

2024 ОНЫ 10 САРЫН 29 1

Усны шинжилгээний дүгнэлтээр унд ахуйд хэрэглэхэд боломжтой гэж дүгнэв. Хөрс ямар нэг өртөлтөнд өртөөгүй механик болон хими шинж чанар хэвийн.

<u>Зургаа. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт</u>

Жуулчны мэдээллийн төв” байгуулах ажлын хүрээнд байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн орчны хяналт мониторингийн ажлыг зохион байгуулж, орон нутагт төслийн танилцуулгыг хийсэн.

Зураг 7: Орон нутагт төслийн танилцуулга хийж буй

Долоо . Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
	Хөвсгөл аймгийн Байгаль орчины газар	Тайлан	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлан	11-р сарын 01-ний дотор	-	ХУТХГ-ын хамгаалалтын захиргаа Хөвсгөл аймгийн Байгаль орчны газар	Мөрөн хот, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон
	Байгаль орчины яамны Хүрээлэн буй орчны бодлого хэрэгжилтийн газар	Тайлан	Тухайн жилийн БОМТ	12-р сарын 1-ний дотор	-		Улаанбаатар хот

Найм. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт

Энэхүү төслийн хувьд иргэд оршин суугчдад үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байна.